



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Асгат сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/047 /НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай сум
2025 он

Төрийн Аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Заяа

Утас: 90088028

Цахим хаяг:

Гэрээт аудитор : Ц.Алтантуул

Утас: 91195554

Цахим хаяг: tuul9565@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	
Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	



АСГАТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА М.ДАГИЙ-Д

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.21 № 207
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Асгат сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Асгат сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь эрүүл мэндийн даатгалын сангаас 619.4 сая төгрөгийн санхүүжилтийн орлого авахаар төлөвлөснөөс 530.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэн, 88.6 сая төгрөгийн санхүүжилтийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулсан байна.

Аудитын гол асуудал

Асгат сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгуудад дүгнэлт өгөх аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

2024 оны үйлчилгээ авсан 1614 иргэн, үүнээс хэвтэн эмчлүүлсэн 287, урьдчилан сэргийлэх үйлчилгээ 547, дуудлага 780 иргэн байна. Тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт арга хэмжээний хүрээнд 40 ажил төлөвлөснөөс биелэлт 90 хувь байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:/disk/Албан бичиг/Дүгнэлт

81-577848

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>78,632,196.53</u>	<u>171,155,865.73</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,645,099.95	1,256,046.50
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,645,099.95	1,256,046.50
3121	Төгрөг	4,645,099.95	1,256,046.50
31211	Төрийн сангийн харилцах	4,645,099.95	1,256,046.50
33	АВЛАГА	9,258,870.17	96,670,635.87
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	9,258,870.17	96,084,635.87
335	Бусад авлага	-	586,000.00
33510	Байгууллагаас авах авлага	-	586,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	64,728,226.41	73,229,183.36
351	Түүхий эд материал	24,735,804.25	29,032,275.20
35110	Тусгай зориулалттай материал	180,000.00	180,000.00
35130	Эм боох материал	24,555,804.25	28,852,275.20
354	Хангамжийн материал	39,992,422.16	44,196,908.16
35410	Бичиг хэргийн материал	783,940.00	829,330.00
35420	Аж ахуйн материал	36,070,001.16	39,109,862.16
35450	Барилгын засварын материал	-	1,740,000.00
35460	Хүнсний материал	3,138,481.00	2,517,716.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>421,366,414.31</u>	<u>406,348,557.74</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	421,366,414.31	406,348,557.74
392	Биет хөрөнгө	416,934,414.31	401,916,557.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	400,275,142.75	400,275,142.75
39202	Хуримтлагдсан элэгдэл	(37,399,699.92)	(45,315,147.36)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	61,500,000.00	61,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(49,687,500.00)	(54,937,500.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	83,728,270.16	92,654,144.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(45,819,451.88)	(56,051,125.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,015,739.60	14,290,739.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,018,760.75)	(10,840,370.24)
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,346,801.84	6,346,801.84
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,346,801.84)	(6,346,801.84)
39217	Ном	340,674.35	340,674.35
393	Биет бус хөрөнгө	4,432,000.00	4,432,000.00
39301	Програм хангамж	910,000.00	910,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(910,000.00)	(910,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,432,000.00	4,432,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>499,998,610.84</u>	<u>577,504,423.47</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>5,259,952.92</u>	<u>856,964.00</u>

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,259,952.92	856,964.00
413	Өглөг	5,259,952.92	856,964.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,460,630.52	506,964.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,799,322.40	350,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	494,738,657.92	576,647,459.47
51	Засгийн газрын хувь оролцоо	494,738,657.92	576,647,459.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	89,891,683.90	89,891,683.90
51101	Өмч: - төрийн	89,891,683.90	89,891,683.90
512	Хуримтлагдсан үр дүн	395,341,456.70	477,250,258.25
51210	Өмнөх үеийн үр дүн	362,944,737.67	395,341,456.70
51220	Тайлант үеийн үр дүн	32,396,719.03	81,908,801.55
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,505,517.32	9,505,517.32
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	499,998,610.84	577,504,423.47

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	455,750,339.82	671,090,493.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,692,801.09	13,499,433.22
120	Нийтлэг татварын бус орлого	19,692,801.09	13,499,433.22
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	12,487,279.00	9,200,873.84
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	7,205,522.09	4,298,559.38
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	436,057,538.73	657,591,060.18
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	30,100,000.00	2,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	30,100,000.00	2,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	32,920,164.00	36,182,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,638,100.00	36,182,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	373,037,374.73	619,408,960.18
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	373,037,374.73	619,408,960.18
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	423,353,620.79	589,181,691.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	423,353,620.79	589,181,691.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	418,756,829.46	586,311,445.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	279,643,956.09	402,241,192.66
210101	Үндсэн цалин	192,037,507.18	247,373,304.81
210102	Нэмэгдэл	54,903,733.91	122,307,767.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,045,000.00	1,572,000.00
210104	Урамшуулал	29,657,715.00	30,988,120.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,027,741.92	51,317,789.06
210201	Тэтгэврийн даатгал	24,652,779.94	34,471,001.36
210202	Тэтгэмжийн даатгал	2,657,944.59	4,055,411.94

210203	ҮОМШӨ-ний даатгал	2,077,864.23	2,741,645.90
210204	Ажилгүйдлийн даатгал	508,248.64	2,009,946.01
210205	Эрүүл мэндийн даатгал	5,130,904.52	8,039,783.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,239,620.07	30,311,041.93
210301	Гэрэл, цахилгаан	1,590,408.67	1,518,641.93
210302	Түлш, халаалт	24,049,211.40	27,592,400.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	1,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,235,954.15	21,314,824.00
210401	Бичиг хэрэг	523,270.00	797,410.00
210402	Тээвэр, шатахуун	9,849,381.15	12,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	820,800.00	916,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,862,503.00	7,101,214.00
2105	Нормативт зардал	30,889,212.37	42,432,093.12
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,367,619.17	34,230,628.12
210502	Хоол, хүнс	5,521,593.20	8,201,465.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,802,500.00	5,751,100.00
210604	Урсгал засвар	1,802,500.00	5,751,100.00
2107	Томилолт, зочны зардал	3,640,000.00	5,222,000.00
210702	Дотоод албан томилолт	3,640,000.00	5,222,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,757,700.00	1,434,074.00
210802	Аудит, багалгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,080,000.00	864,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	50,574.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	553,200.00	440,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,520,144.86	26,287,330.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	409,800.00	2,068,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,110,344.86	24,218,730.41
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,596,791.33	2,870,246.67
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,596,791.33	2,870,246.67
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,596,791.33	2,870,246.67
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	32,396,719.03	81,908,801.55
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	32,396,719.03	81,908,801.55

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	398,496,543.73	569,067,419.31
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	398,496,543.73	569,067,419.31
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	30,100,000.00	2,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	30,100,000.00	2,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	32,920,164.00	36,182,100.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,638,100.00	36,182,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	335,476,379.73	530,885,319.31
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	335,476,379.73	530,885,319.31
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	394,978,642.86	572,456,472.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	394,978,642.86	572,456,472.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	390,381,851.53	569,586,226.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	268,709,774.86	402,287,973.07
210101	Үндсэн цалин	147,826,698.78	222,208,537.84
210102	Нэмэгдэл	91,837,870.41	114,986,730.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,010,999.67	3,366,000.00
210104	Урамшуулал	25,034,206.00	61,726,704.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,206,131.80	50,526,800.00
210201	Тэтгэврийн даатгал	32,204,500.00	34,358,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,788,900.00	4,042,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,031,000.00	2,066,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	757,800.00	1,976,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,423,931.80	8,084,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,238,808.67	30,311,853.33
210301	Гэрэл, цахилгаан	1,590,408.67	1,519,453.33
210302	Түлш, халаалт	24,048,400.00	27,592,400.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	1,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,946,900.00	17,442,800.00
210401	Бичиг хэрэг	535,900.00	741,500.00
210402	Тээвэр, шатахуун	9,235,500.00	11,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	820,800.00	916,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	654,700.00	175,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,700,000.00	4,610,100.00
2105	Нормативт зардал	26,946,336.20	50,018,025.69
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,033,336.20	40,912,325.69
210502	Хоол, хүнс	5,913,000.00	7,230,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,875,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,351,500.00	8,881,100.00
210604	Урсгал засвар	1,931,500.00	8,881,100.00
2107	Томилолт, зочны зардал	3,640,000.00	5,222,000.00
210702	Дотоод албан томилолт	3,640,000.00	5,222,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,932,600.00	1,535,374.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,080,000.00	864,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	50,574.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	553,200.00	440,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	174,900.00	101,300.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	409,800.00	3,360,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	409,800.00	3,360,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,596,791.33	2,870,246.67
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,596,791.33	2,870,246.67
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,596,791.33	2,870,246.67
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	3,517,900.87	(3,389,053.45)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	3,517,900.87	(3,389,053.45)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,127,199.08	4,645,099.95
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,645,099.95	1,256,046.50

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	89,891,683.90	9,505,517.32	395,341,456.70	494,738,657.92
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	89,891,683.90	9,505,517.32	395,341,456.70	494,738,657.92
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	81,908,801.55	81,908,801.55
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	89,891,683.90	9,505,517.32	477,250,258.25	576,647,459.47

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	605,746,700.00	536,274,372.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	605,746,700.00	536,274,372.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	605,746,700.00	536,274,372.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	404,214,100.00	402,287,973.07
210101	Үндсэн цалин	258,612,000.00	222,208,537.84
210102	Нэмэгдэл	95,114,100.00	114,986,730.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,488,000.00	3,366,000.00
210104	Урамшуулал	46,000,000.00	61,726,704.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,526,800.00	50,526,800.00
210201	Тэтгэврийн даатгал	34,358,200.00	34,358,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,042,100.00	4,042,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,021,100.00	2,066,100.00

210204	Ажилгүйдлийн даатгал	2,021,100.00	1,976,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,084,300.00	8,084,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,760,400.00	17,442,800.00
210401	Бичиг хэрэг	1,904,900.00	741,500.00
210402	Тээвэр, шатахуун	13,910,500.00	11,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,085,000.00	916,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	904,900.00	175,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,955,100.00	4,610,100.00
2105	Нормативт зардал	62,749,800.00	50,018,025.69
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	49,265,300.00	40,912,325.69
210502	Хоол, хүнс	9,584,500.00	7,230,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,900,000.00	1,875,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,825,000.00	5,881,100.00
210604	Урсгал засвар	9,125,000.00	5,881,100.00
2107	Томилолт, зочны зардал	5,240,000.00	5,222,000.00
210702	Дотоод албан томилолт	5,240,000.00	5,222,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,729,600.00	1,535,374.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	864,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	80,000.00	79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	128,000.00	50,574.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	629,600.00	440,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	229,000.00	101,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,518,900.00	3,360,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,518,900.00	3,360,300.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,645,099.95
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,256,046.50

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	36,182,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	36,182,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	33,311,853.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,311,853.33
210301	Гэрэл, цахилгаан	1,519,453.33
210302	Түлш, халаалт	27,592,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,870,246.67
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,870,246.67
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	2,870,246.67

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Асгат сумын эрүүл мэндийн төвийн зорилго: Эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг иргэдэд жигд хүртээмжтэй чанартай хүргэх

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд 80 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Асгат сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
8. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль
10. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
11. Эрүүл мэндийн тухай хууль
12. НЭМ-ийн тусламж үйлчилгээний тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар:

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Асгат сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:

Санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Асгат сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 77,505.8 мянган төгрөгөөр буюу 15.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,645.1	1,256.0	3,389.1
Авлага	9,258.8	96,670.6	(87,411.8)
Бараа материал	64,728.2	73,229.1	8,500.9
Үндсэн хөрөнгө	421,366.4	406,348.5	(15,017.9)
Нийт хөрөнгө	499,998.6	577,504.4	77,505.8
Өглөг	5,259.9	856.9	4,403.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	494,738.6	576,647.5	81,908.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	499,998.6	577,504.4	77,505.8

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Мөнгөн хөрөнгийн дансны хувьд 3,389.1 мянган төгрөгөөр буурсан нь эхний үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Авлагын эхний үлдэгдэл 9,258.8 мянган төгрөг байсныг барагдуулсан тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага 96,670.6 мянган төгрөгийн авлага үүссэн байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 64,728.2 мянган төгрөг байсан бөгөөд төсвийн хөрөнгөөр 73,754.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 65,253.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 73,229.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 8,500.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд хөрөнгө оруулалтаар 9,200.8 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, элэгдэл тооцсоноор жилийн эцэст 406,348.5 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 24,218.7 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 4,403.0 мянган төгрөгөөр буурсан нь өглөгөө төлж барагдуулсантай холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 77,505.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 569,564.6 мянган төгрөг, нийт зарлагыг 569,564.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна

3.5.1. Төсвийн гүйцэтгэл

Тухайн байгууллага нь тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 530,885.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоос 2,000.0 мянган төгрөг, нийт 532,885.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс гүйцэтгэл 536,274.4 мянган төгрөг буюу 100.7 хувьтай байгаа нь эхний үлдэгдлээс эрх нээлгэн зарцуулсантай холбоотой байна.

/мянган төгрөгөөр/					
Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөв лөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Орон нутгийн төсвөөс санхүүжих					
80302	Нэг иргэнд ногдох норматив зардал	386,147.6	415,733.1	-29,585.5	99.6%
81603	Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	146,737.7	118,541.3	28,196.4	80.8%
83603	Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан		2,000.0	2,000.0	100%
НИЙТ		532,885.3	536,274.4	3,389.1	100.7%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.2. Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 36,182.1 мянган төгрөгийн санхүүжилт авсан. Гүйцэтгэлээр 30,311.8 мянган төгрөгийг тогтмол зардалд, 3,000.0 мянган төгрөгийг урсгал засварын зардалд зарцуулж 2,870.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/мянган төгрөг/

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Шууд гэрээ байгуулах	Түлш шатах тослох материал худалдан авах	24,048.40	27,592.40
2	Шууд гэрээ байгуулах	Хүнсний материал худалдан авах	5,913.0	7,230.70
ДҮН			29,961.40	34,823.10

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Асгат сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүлд аудит ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Заяа, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Асгат сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2025 оны 02 дүгээр сарын 15-ны өдөр 06 дугаартай албан тоотой ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 589,181.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,658,8 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Асгат сумын Эрүүл мэндийн төвийн шилэн дансны мэдээллийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн байна* гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Асгат сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,273.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 1,396.2 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1,273.6	2	1,273.6	100%
Зөвлөмж	2	1,396.2	2	1,396.2	100%
Нийт дүн	4	2,669.8	4	2,669.8	100%

Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар цалингийн нэмэгдэл илүү тооцож олгосон 292.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

5.1 Төлбөрийн акт:

Ажилтанд 292.3 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдлийг илүү тооцож олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага хүргүүлээгүй

5.3 Зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛГИЙН НЭГТГЭЛ
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл


Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруу-лаагүй		Зөвлөмж	
Дүн							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Илүү цагийн нэмэгдэл илүү тооцож олгосон	1	292.3			1	292.3						
Дүн	1	292.3			1	292.3						

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР **Д.БАТ-УНДРАА**
 АУДИТЫН МЕНЕЖЕР **Х.БОЛДБААТАР**
 АХЛАХ АУДИТОР **Г.ЗАЯА**
 БОЛОВСРУУЛСАН
 СҮЛД АУДИТ ХХК-ИЙН
 ГЭРЭЭТ АУДИТОР **Ц.АЛТАНТУУЛ**



ОГНОО: 2025-02-22